



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн өргөн
чөлөө 3, Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101 Утас: (976) 70442273
Цахим шуудан: info@bayanhongor.gov.mn
Цахим хаяг: www.bayanhongor.gov.mn

2026.01.20 № 2/113

танай _____ -ны № _____ -т

Г ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТЭСТ

Баянхонгор аймагт гадаадын зээл
тусламжаар хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн 2025
оны хэрэгжилтийг нэгтгэн хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.
Хавсралт 2 хуудастай.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА П. ОТГОНБЯАР



626310023

**БАЯНХОНГОР АЙМАГТ ГАДААДЫН ЗЭЭЛ ТУСЛАМЖААР ХЭРЭГЖИЖ
БУЙ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН 2025 ОНЫ ХЭРЭГЖИЛТ**

2025 оны 01 дүгээр сарын 19

Номгон

Д/д	Төслийн нэр	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зарцуулсан хөрөнгө, эх үүсвэр	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хэрэгжилт
1	2	3	4	5	6	7
1	Тэгш хүртээмжтэй цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь	"Тэгш хүртээмжтэй, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь" төслийн хоёрдугаар үе шат: Баянхонгор сумын сургууль, цэцэрлэгийн Баян-Ойт цогцолбор, Оточ мандал өрхийн эрүүл мэндийн төвийг тохижуулах	40-50 сая Хүүхдийг ивээх сан Япон улсын Гадаад хэргийн яам	Ээлтэй орчин бүрдсэн байгууламжийн тоо	2	"Тэгш хүртээмжтэй, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь" төслийн хоёрдугаар үе шат Баянхонгор сумын сургууль, цэцэрлэгийн Баян-Ойт цогцолбор, Оточ мандал өрхийн эрүүл мэндийн төвийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэн тохижилтийн ажил хийгдсэн. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төв байгуулагдсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ээлтэй сэтгэл зүйн орчин бүрдүүлэх чиглэлээр 6 төрлийн сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулсан.
Хэрэгжилтийн дундаж хувь:						100%
2	Эх, хүүхдийн эрүүл мэндийн хөтөлбөр 100 - Child Survival and Development	Хүүхдэд тохиолдох А бүлгийн β-стрептококкийн гаралтай ангина, фарингитын оношилгоо, эмчилгээ; хүүхдийн хэрэх өвчний	-	Хүүхдэд тохиолдох А бүлгийн β-стрептококкийн гаралтай ангина, фарингитын оношилгоо, эмчилгээ; хүүхдийн хэрэх өвчний	70 эмч эмнэлгийн ажилтныг чадавхжуулах 1-12 дугаар ангийн	Хүүхдэд тохиолдох А бүлгийн β-стрептококкийн гаралтай ангина, фарингитын оношилгоо, эмчилгээ; хүүхдийн хэрэх өвчний оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт; хэрэхийн шалтгаант зүрхний олдмол гажгийн оношилгоо, эмчилгээний заавар, зөвлөмжийн дагуу анхан шатны эрүүл мэндийн

1	2	3	4	5	6	7
		<p>оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт; хэрэхийн шалтгаант зүрхний олдмол гажгийн оношилгоо, эмчилгээний заавар, зөвлөмжийн дагуу орон нутагт ажиллаж буй эмнэлгийн мэргэжилтэнд сургалт зохион байгуулж, стрептококк байгаа эсэхийг эрт илрүүлж, цаг алдалгүйгээр тусламж үзүүлж, хүүхдийн өвчлөл, эндэгдэл болоод амьдралын чадамжийг сайжруулах.</p>		<p>оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт; хэрэхийн шалтгаант зүрхний олдмол гажгийн оношилгоо, эмчилгээний заавар, зөвлөмжийн дагуу анхан шатны эрүүл мэндийн байгууллага, ЕБС-ийн эмч мэргэжилтэнд сургалт зохион байгуулах;</p>	<p>хүүхдүүдэд скрининг хийх</p>	<p>мэргэжилтнүүдийг 2 удаагийн сургалтаар чадавхжуулсан. 2. 2025.12.31-ны өдрийн байдлаар 1517 хүүхдэд оношилгоо хийгдэж 144 эерэг тохиолдол илрүүлж эмчлэн эрүүлжүүлэх үйл ажиллагаа хийгдэж төслийн үйл ажиллагаа үргэлжилж байна.</p>
Хэрэгжилтийн дундаж хувь:						90%
3	<p>Сэргийлж болох эх нярайн эндэгдлийг бууруулах нь</p>	-	Төсөв- 11.594.000 төгрөг	-	-	<p>Төсөл хөтөлбөрийн хүрээнд 2025 онд Баянговь, Баянлиг сумын эрүүл мэндийн төвүүдэд телемедицин тоног төхөөрөмж хүлээлгэн өгч, суурилуулалт ба, ашиглалтын мэдээлэл өгч ажилласан. Тус сумдад нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийг ашиглан лавлагаа шатлалаас зөвлөгөө авсан тохиолдол-12, дотоод сургалт- 10, ард иргэдэд эрүүл мэндийн</p>

1	2	3	4	5	6	7
						сургалт мэдээлэл-410 удаа хүргэсэн. Төслийн хүрээнд 100 ширхэг суулгац ирснээс 11 үйлчлүүлэгчид тавьсан.
Хэрэгжилтийн дундаж хувь:						100%
4	Хамтарсан багийн гишүүдийн айл өрхөд үйлчилгээ үзүүлэхэд хэрэглэх, тараах 6-10 насны хүүхэдтэй эцэг эхчүүдэд зориулсан мэдээллийн багц боловсруулах	Хамтарсан багийн гишүүдийн айл өрхөд үйлчилгээ үзүүлэхэд хэрэглэх, тараах 6-10 насны хүүхэдтэй эцэг эхчүүдэд зориулсан сургалтын гарын авлага бэлтгэх	НҮБ-ын хүүхдийн төлөө сан – 9,600,000 төгрөг	Хэвлүүлсэн эх бэлтгэл (гарын авлага)-ийн тоо	3000	Сургуулийн бага нас буюу 6-10 насны хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан сургалтын гарын авлагыг боловсруулан 3000 ширхгийг хэвлүүлсэн. 2025 онд 451 эцэг эхэд сургалтыг зохион байгуулсан. Сургалтын агуулгад хүүхдийн насны онцлог, бие махбодын хөгжлийн онцлог, сэтгэл зүйн хөгжил, оюун ухаан суралцахуйн хөгжил, танин мэдэхүй нийгэмшихүйн хөгжил, эцэг эхчүүдэд өгөх зөвлөгөө, хүмүүжлийн зэрэг арга, хүүхдийн хөгжил, оролцоог дэмжих арга зүй, гэр бүл дэх хүүхэд хамгаалал багтсан.
Хэрэгжилтийн дундаж хувь:						100%
5	"Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь" ENSURE	Пассив хаусын барилгыг орон нутгийн тусгай хамгаалалттай газар байршуулах, нарны эрчим хүчний үүсвэр, тохижилтын ажлыг санхүүжүүлсэн		Монголын унаган байгалийн хүлцэл тогтворжилтыг хангах нь төслөөс Баянцагаан сумын орон нутгийн тусгай хамгаалалттай газар байршуулахаар пассив хаусыг байрлуулах, мөн	Баянцагаан сумын орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт ан амьтны хамгаалах, байгаль хамгаалагч нар байрлах, мөн тухайн	Баянцагаан сумд 2024 онд орон нутгийн хөгжлийн сан болон Монголын унаган байгалийн хүлцэл тогтворжилтыг хангах нь төслөөс сумын орон нутгийн тусгай хамгаалалттай газар байгуулахаар пассив хаусыг худалдан авсан бөгөөд тус байшинг орон нутгийн тусгай хамгаалалттай бүс нутагт амьдарч байгаа малчид, ард иргэдэд мөн аялагчдад зориулсан

1	2	3	4	5	6	7
				гадна, дотор тохижилтын Ажлыг хийж гүйцэтгэсэн	бүс нутгийн малчдад сургалт мэдээлэл өгөх	сургалт, мэдээлэл өгөх, орон нутаг тэнхим хэлбэрээр ашиглах зориулалттай Баянцагаан уулын Урд зуслангийн эхэнд байршуулсан бөгөөд худалдан авах, байрлуулахад мөн дотно тохижилтын ажлыг хийж гүйцэтгэхэд ENSURE төслөөс санхүүжүүлэн хамтран ажилласан.
Хэрэгжилтийн дундаж хувь:						100%
6	Тогтвортой байдлын төлөө Баянхонгор аймгийн бие даасан хоршоод бий болгох Goats буюу Ямаа төсөл		Франц улсын Хермес Текстиль группийн санхүүжилт буцалтгүй тусламжаар			Бүгд Найрамдах Франц улсад төвтэй "AVSF" (Хил хязгааргүй малын эмч нар ба агрономчид) олон улсын байгууллага нь 2024 оны 04 дүгээр сараас эхлэн "GOATS" буюу "ЯМАА" төслийг "Тогтвортой байдлын төлөө Баянхонгор аймгийн бие даасан хоршоод" бий болгох зорилгоор Шинэжинст, Баян-Өндөр, Баянцагаан сумдад хэрэгжүүлж байна. Шинэжинст сумын Цармын сувд хоршооны 15 өрх, Баян-Өндөр сумын Идрэнгийн цагаан сувд хоршооны 7 өрх, Баянцагаан сумын Баянгичгэнэ хоршооны 5 өрхийг сонгон 2025 оны 02 сард нийт 27 өрхийн ямаан сүргээс 134 ширхэг ноолуурын дээж бэлтгэн Мал эмнэлийн хүрээлэнгийн лабораторид шилжүүлсэн. Мөн 2025 оны 4 сард Шинэжинст сумын хоршооны 15 өрх, Баян-Өндөр сумын хоршооны 10 өрх, Баянгичгэнэ хоршооны 15 өрхийг

1	2	3	4	5	6	7
						<p>сонгож хаврын ангилан ялгалт, шилэн сонголтын ажлыг хийсэн ба 1057 эм ямааг ангилж ээмэгжүүлсэн. Төслийн хүрээнд Шинэжинст, Баян-Өндөр сумын шилмэл ямаан сүрэгтэй өрхүүдээс ухна, ишиг бойжуулах ажлыг эхлүүлсэн. Энэ хүрээнд 06 дугаар сарын 05-19-ний өдрийн хооронд Шинэжинст сумын хоршооны 8 өрхөөс 70 ухна ишиг, Баян-Өндөр сумын хоршооны 7 өрхөөс 48 ухна ишиг сонгосон. Ухна ишигний дахин сонголтыг 9 сард зохион байгуулж Шинэжинст сумын хоршооны 8 өрхөөс 62, Баян-Өндөр сумын хоршооны 7 өрхөөс 40 буюу нийт 102 ухна ишгийг сонгосон.</p> <p>Малын өвс тэжээл бэлтгэх ажлын хүрээнд: 2025-2026 оны өвөлжилтийн бэлтгэл хангах зорилгоор 11 сарын байдлаар Шинэжинст, Баян-Өндөр сумдын хоршоод өөрсдийн өвс тэжээлийн нөөц сангаасаа нийт 1 тн өвс, 22тн хивэг, 7 тн овьёосыг 51,485,000 төгрөгөөр бэлтгэсэн байна. Төсөл хэрэгжиж буй 3 хоршооны нийт гишүүнчлэлийн тоо 296 болж 6 хувиар нэмэгдүүлсэн байна. Хоршоод бүх гишүүдийнхээ хурлыг жилд 2 удаа зохион байгуулж хэвшсэн ба хурлаараа хоршооны асуудлаа хэлэлцэж бүх гишүүдээрээ шийдвэрлэдэг</p>

1	2	3	4	5	6	7
						<p>ардчилсан засаглалтай болж чадсан. Тогтвортой ноолуур баталгаажуулалтын систем ба Хариуцлагатай нүүдэлчин үндэсний стандартыг нэгтгэж 53 шалгуур бүхий "Хариуцлагатай нүүдэлчид-Тогтвортой ноолуур интернейшнл" олон улсын ноолуурын баталгаажуулалтыг зорилтод 3 хоршоонд хэрэгжүүлэхээр болж олон улсын ноолуурын баталгаажуулалтын дотоод хяналт хийх сургалтыг 10 дугаар сарын 21-24-ний өдрийн хооронд зохион байгуулсан. Ээлтэй баялаг дундын хоршоо, зорилтод 3 хоршоо нь Францын тансаг зэрэглэлийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг компанитай 3 жилийн хамтын ажиллагаатай Санамж бичгийг 2024 оны 4 сард байгуулан ажиллаж байна. Хамтын ажиллагааны хүрээнд 2025 онд 3 хоршоо 16,6 тн цагаан түүхий ноолуур бэлтгэж, 8,3 тн самнасан ноолуурыг экспортод захиалгын дагуу нийлүүлсэн. Түүхий ноолуурын боловсруулалтыг дотоодын боловсруулах үйлдвэр болох "Ханбогд кашимер" ХХК болон "Өгөөж шим" ХХК-нд гүйцэтгэсэн. Самнасан ноолуурын микроны чанар дунджаар 16.2-16.5 үзүүлэлттэй байна. Ээлтэй баялаг дундын хоршоо нь бусад</p>

1	2	3	4	5	6	7
						<p>гишүүн хоршоодынхоо самнасан ноолуураар бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэн ажиллаж байна.</p>
Хэрэгжилтийн дундаж хувь:						100%
7	<p>WIFI буюу Монголын нүүдлийн бэлчээрийн мал аж ахуйд түшиглэсэн чанартай, орон нутгийн махны үйлдвэрлэлийг хөгжүүлэх</p>			<p>Төслийн зорилтод хүрэхийн тулд 3 бүрдэл хэсгийн хүрээнд төсөл хэрэгжинэ. Баянхонгор аймгийн төслийн зорилтод 4 хоршооны бэлтгэсэн мах эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан байна. "Баянхонгорын гарал үүсэл" мах үйлдвэрлэл, боловсруулалтын тогтолцоог бий болгож, хот суурин газрыг чанар, стандартын шаардлагад нийцсэн махаар тогтмол хангана. Зорилтод хоршоодын гишүүн, мах үйлдвэрлэгч</p>		<p>"WIFI" буюу Монголын нүүдлийн бэлчээрийн мал аж ахуйд түшиглэсэн чанартай, орон нутгийн махны үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилготой төсөл Богд, Бөмбөгөр, Жинст, Баянцагаан сумдад хэрэгжиж байна. Зорилтод 4 сумын малчны бүлгүүдэд 1 сарын 06-24-ний хооронд Малын эмийн бодисын зөв хэрэглээ шимэгчлэх өвчний талаарх сургалт зохион байгуулсан. Сургалтад 311 малчин хамрагдсан ба сургалтыг ХААИС-Мал эмнэлгийн их сургуулийн багш, паразитлогич, хор судлаач, доктор И.Хатанбаатар чиглүүлж орон нутгийн сургагч багшаар Бөмбөгөр сумын МЭТ-ийн дарга, улсын байцаагч Б.Нямбат, Баянцагаан сумын МЭТ-ийн дарга, улсын байцаагч Б.Батхонгор нарыг бэлтгэж сургалтын үеэр дагалдуулан чиглүүлэг хийж, дадлагажуулсан. Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн салбарын 2025 оны Мал эмнэлгүүдийн эмч, мэргэжилтнүүдийн зөвлөгөөнийг 4 сарын 21,22-нд зохион байгуулсан.</p>

1	2	3	4	5	6	7
				<p>нүүдэлчин малчдад тогтвортой, ашигтай зах зээлийг бий болгох.</p>		<p>Тус зөвлөгөөний үеэр WiFi махны төсөл хэрэгжиж буй Богд, Жинст, Баянцагаан, Бөмбөгөр сумдын улсын мал эмнэлгийн тасгийн мэргэжилтнүүд, болон хувийн мал эмнэлгийн 11 эмчид мал эмнэлгийн мөгших тогтолцоог сайжруулахад зориулж зөөврийн компьютер гардуулав.</p> <p>Малын шимэгчлэх өвчнийг эмчлэх арга хэмжээг хэрэгжүүлэх талаар 4 сумын малчдын бүлгүүдтэй уулзалт хийж ширхтэх өвчний талаарх мэдээлэл, ширхтэх амьдралын мөчлөг, ширхтэх өвчнийг эмчлэх арга-өмнөх хэрэгжүүлж байсан арга дээр зөвлөмж өгч одоо хэрэгжүүлэх аргыг дагаж мөрдөх зааварчилгаа өгсөн. Ширхтэх өвчнийг эмчлэх ажил буюу мал угаалгыг төслөөс эмийн бодисоор дэмжиж, сумын хариуцсан малын эмч нартай хамтарч хийсэн ба мал угаалгад 4 сумын 98 өрхийн 64249 бог мал, 204 бод мал хамрагдав. Угаалгын ажлын үр дүнг хэмжихийн тулд угаахаас өмнөх үзлэгийг 4 сумын 13 бүлэг 52 өрхийн 832 бог малд, угааснаас 60 хоногийн дараа 2 дахь үзлэгийг 2 сумын 5 бүлэг, 16 өрхийн 256 бог малд сумын төрийн болон хувийн мал эмнэлгийн малын эмч нартай хамтран хийлээ. Нэг бүлгээс 4 насны /1 наснаас 4 мал/ нийт 16 малд үзлэг хийж</p>

1	2	3	4	5	6	7
						<p>үзлэгийн тэмдэглэл хөтөлсөн.</p> <p>Малын эмч малчин хоёрын үр ашигтай хамтын ажиллагааны гэрээний загварыг бий болгох зорилгоор аймгийн Мал эмнэлгийн газар, Франц улсын малчид болон Мал эмнэлгийн хамтарсан байгууллага болох FEVEС-ийн малчин, малын эмч, малчны байгууллагын төлөөлөл болох 4 зөвлөх, нийт 10 хүний бүрэлдэхүүнтэй баг Бөмбөгөр, Баянцагаан сумдад ажиллав. Зөвлөх багийнхан 2 баг болон хуваагдаж хоршооны малчдын бүлгүүд дээр очин гэрээний талаар хэлэлцүүлэг хийж, мөн сумдад хоршоодын малчдын төлөөлөл, төрийн болон хувийн мал эмнэлгийн эмч, сумдын удирдлагуудтай мал бүрийн оролцоог хангасан 2 удаагийн зөвлөлдөх уулзалтыг Бөмбөгөр, Баянцагаан сумын нийт 59 оролцогчдод зохион байгуулав.</p> <p>Хэрэглэгчдийг эрүүл, чанартай махаар хангахын тулд эрүүл ахуйн хяналтыг бэхжүүлэх ажлын хүрээнд:</p> <p>9 сард Францын малын эмч, зөвлөхүүд айлчилж махны эрүүл ахуйн талаар 2 үндэсний сургагч багшийг бэлтгэсэн ба Махны эрүүл ахуйн хамтарсан сургалтыг 9 сарын 25-нд Баянхонгор аймагт манхы үйлдвэрүүдийн төлөөллийг</p>

1	2	3	4	5	6	7
						<p>оролцуулан зохион байгууллаа. Мэргэжлийн малын эмч нарын сургалт ба орон нутгийн өсвөр насны хүүхэд залуучуудад малын эмчийн мэргэжлийг сурталчлахад дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд: Малын эмчийн мэргэжлийг сурталчлах, ХААИС-МЭС-тэй танилцах аялал 2025 оны 05 дугаар сарын 05-07-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. Малын эмч мэргэжлийг өсвөр насныханд сурталчлах сургалтын үр дүнд 162 сурагчдаас 8 сурагч малын эмч мэргэжлийг сонгохоор болж, 8 сурагчид Улаанбаатар хотод экскурс аялал зохион байгуулав. “Баянхонгорын гарал үүсэл” мах үйлдвэрлэл, боловсруулалтын тогтолцоог бий болгож, хот суурин газрыг чанар, стандартын шаардлагад нийцсэн махаар тогтмол хангах ажлын хүрээнд: Зорилтод 4 сумын малчдын 4 хоршоодын 9 төлөөллүүд 2025 оны 04 дүгээр сарын 02-нд Улаанбаатар хотод Махны холбоо болон махны 6 үйлдвэрүүдтэй уулзалт хийсэн. Чанартай махны сүлжээг хөгжүүлэхийн тулд сайн туршлага, зохистой байдлыг төлөвшүүлэх</p>

1	2	3	4	5	6	7
						<p>зорилгоор ашиг хүртэгч хоршоодын малчид, бүлгийн ахлагч нарт сургалт таниулга хийв. Үүнд:</p> <p>1.“Мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангахад малчин эмэгтэйчүүд болон залуучуудын оролцоо” сэдэвт Бэлчээрийн үндэсний VIII форумд 2025 оны 09 дүгээр сарын 24,25-ны өдрүүдэд төслийн зорилтод 4 сумаас 4 малчин оролцсон.</p> <p>Ашиг хүртэгч хоршоодын үйл ажиллагааны чадавх, засаглалыг бэхжүүлэх ажлын хүрээнд:</p> <p>Төслийн зорилтод 4 сумын хоршоодын бүх гишүүдийн хурал 2025 оны 01 дүгээр сард зохион байгуулагдав. Хоршоодын бүх гишүүдийн хуралд оролцож төслийн хэрэгжилтийн мэдээлэл, ноолуур боловсруулалтын техникийн тайлан, хоршооны үнэлгээг хийж ажиллалаа.</p>
Хэрэгжилтийн дундаж хувь:						100%
8	Хангайн бүсийн уулын ландшафтыг нөхөн сэргээж, хамгаалах замаар экосистемийн үйлчилгээ болон орон нутгийн	Ландшафтын нэгдмэл түвшинд сумын нутаг дэвгэрийн хөгжлийн төлөвлөгөө, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө,	4,000,000 сая төгрөг	Төсөл хөтөлбөр хэрэгжсэнээр	Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө,	Архангай аймагт төслийн анхан шатны сургалтад Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Засаг даргын орлогч Б.Өсөхбаяр, Бэлчээр газар тариалан хариуцсан мэргэжилтэн Ц.Мөнхбаатар, Газрын даамал Д.Номинчимэг нар хамрагдсан. Төслийн зохицуулагчаар

1	2	3	4	5	6	7
	иргэдийн амьжиргааг сайжруулах нь” төсөл 2025-2030 он	бэлчээрийн менежментийн төлөвлөгөө, сумын ойн менежментийн төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх, үр дүнг олон нийтэд тайлагнах /Эрдэнэцогт сумд хэрэгжих/			бэлчээрийн менежментийн төлөвлөгөө, сумын ойн менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулах	Д.Цэдэвдоржийг сонгон. шалгаруулан, ажиллуулж байна. 2025 онд сургалт мэдээллийг сум орон нутгийн удирдлагуудад өгсөн. Төсөд 2026 оноос эхлэн хэрэгжинэ
Хэрэгжилтийн дундаж хувь:						Тооцох боломжгүй
9	“Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь” төсөл хөтөлбөр 2025-2030	Уур амьсгалын өөрчлөлтөд малчид иргэд олон нийтийн дасан зохицох, даван туулах чадавхыг нэмэгдүүлэх /Эрдэнэцогт сум/	2,500,000 төгрөг	Төсөл хөтөлбөр хэрэгжсэнээр	Малчдын уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадвар мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх	Эхний шатны сургалтад ИТХ-ын дарга, сумын Засаг дарга, Тамгын газрын дарга, багийн Засаг дарга нарын бүрэлдэхүүнтэй 17 төрийн албан хаагч хамрагдсан. Сумын 121 малчин өрхөөс анхан шатны судалгааг авч хүргүүлсэн. 2025 онд сургалт мэдээллийг сум орон нутгийн удирдлагууд өгсөн. 2026 оноос төсөл хэрэгжиж эхэлнэ.
Хэрэгжилтийн дундаж хувь:						Тооцох боломжгүй
Төсөл хөтөлбөрийн нийт хэрэгжилтийн хувь						98,57

ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА  П.ОТГОНБАЯР

ХЭРЭГЖИЛТ НЭГТГЭСЭН:
ГАДААД ХАРИЛЦААНЫ АСУУДАД ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН  Б.ЭНХЗАЯА